



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/06

Шивээговь сум

Төв хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх,
түрж булшлах ажилд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.6, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.3, 9.4.4, 9.4.10, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шивээговь сумын төв хогийн цэгийн хог хаягдлыг түрэх, цэвэрлэх, булаах ажлыг 2023 оны 02 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Төв хогийн цэгийг цэвэрлэх, хогийн цэгийн нүх, зам харгуйг тэгшлэх ажлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Уг ажилд зарцуулагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг "Хог хаягдлын зардал"-аас зохих журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4. Ажлыг чанартай зохион байгуулж, ажлын тайланг журмын дагуу гарган санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (О.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.СУГАРМАА



С:

...

..

Засаг даргын Тамгын газрын даргын
... Оны ...-р сарын ...-ний өдрийн
... Дугаар тушаалын хавсралт



и Төв хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх түрж, булшлах ажилд зарцуулагдах төсөв

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын нэрий		Тоо ширхэг	Нэгжийн үнэ/тег/	Нийт үнэ /тег/
Төв хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх түрж, булшлах ажил	Шатахуун	Дизель	480 литр	4010	1.924.800
		АИ292	29 литр	2560	75.200
Нийт					2.000.000

Төсөв гаргасан:

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн *Омтоно* О.Отгонбаяр